



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

Хөрөнгө оруулалтын үр ашгийг төлөвлөх,
бодит үр нөлөөг тооцох бодлого зохицуулалт
дутагдаж байна.

Аудитын код: ГАГ-2019/01-ГА

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг
2019 оны 04 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 70523020 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор: П.Энхбаяр
Цахим хаяг: enkhbayarpurev@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар -----3
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй-----5
Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа	БҮЛЭГ А. Хууль журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээ төлөвлөж батлуулсан байна.
Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа	А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт салбарын болон орон нутгийн бодлогот нийцэж байна.-----6-7
Аудитор П.Энхбаяр	А.2 Хууль журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулаагүй байна. -----7-9
2018 оны 3 дугаар сар	БҮЛЭГ Б. ХАА-г журмын дагуу зохион байгуулаагүйгээс хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр нөлөө хангалтгүй байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас,7052-2734 дугаарын факсаар харилцана уу	Б.1. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.-----10-13
ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3- р байр	Б.2. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу гүйцэтгэх үүргээ бүрэн биелүүлэхгүй байна.-----13-16
	Б.3. Захиалагчийн тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.-----16-18
	Б.4.Хөрөнгө оруулалтын үйл явцад журмын дагуу хяналт тавьж үнэлсэн байна-----18-20
	БҮЛЭГ В Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцдоггүй байна.
	В.1 Улсын төсвийн зарим хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтод түвшинг хангахгүй байна.-----21
	В.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцоогүй байна---21-23
	Дүгнэлт-----24
	Бүлэг 4. Зөвлөмж-----25
	Холбогдох байгууллагын санал-----24-26
	Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар-----27
	Тайлан баталгаажуулсан тушаал-----28

Товчилсон үгийн тайлбар

БСШУСС	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайд
ТАХ	Төсөл арга хэмжээ
БНБД	Барилгын норм ба дүрэм
БХТ	Барилгын хөгжлийн төв
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа болон ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЗДТГ	Засаг даргын тамын газар
ТББ	Тендерийн баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газар
НХХС	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайд
ЗГ	Засгийн газар
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУ	Монгол улсын
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
УТ	Улсын төсөв
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, аудитын нэр

Аудитын нэр: “Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”

Аудитын код: ГАГ-2019/01-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд, Үндэсний аудитын газрын 2019 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан аудитын сэдвийн хүрээнд, нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт: “Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”-нд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах 3 чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэх,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцсон эсэх

Хамарсан хүрээ: Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, болон гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамруулав.

Орон нутагт байршилтай хөрөнгө оруулалтын эрх шилжээгүй төсөл арга хэмжээний хэрэгжилтийн талаарх судалгааг холбогдох маягтаар ҮАГ-т хүргүүлэх тул аудитад хамраагдаагүй болно.

Үндсэн мэдээлэл: МУ-ын 2018 оны Төсвийн тухай хууль 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан бөгөөд уг хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тус аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 23446.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутагт эрх шилжүүлж, 4576.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн байна.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан, шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын судалгаа, үр дүнгийн мэдээллийг боловсрууллаа.

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн зарим барилгын ажлын зураг төсөл нь зохих норм, журмын дагуу зохиогдсон эсэх, батлагдсан төсөв нь бодитой, үнэн зөв тооцоологдсон эсэх, барилга угсралт, засварын ажил нь холбогдох зураг, төсвийн дагуу чанартай хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргуулах зорилгоор аудитад зөвлөх шинжээчийг татан оролцууллаа.

Аудитын хугацаа: Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлэн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд ҮАГ-ын батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 07-нд эхлүүлж, аудитын талбарын ажлыг 2019 оны 2 дугаар сарын 25-ноос 3 дугаар сарын 28-ны өдрүүдэд гүйцэтгэж, дэд тайланг баталгаажуулан, холбогдох судалгаа, зөрчлийн жагсаалтын хамт 2019 оны 4 дүгээр сарын 09-нд ҮАГ-т хүргүүллээ.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг Дорноговь аймгийн Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, аудитын багийн ахлах аудитор Ц.Лүндэгмаа хэрэгжүүлж, аудитор П.Энхбаяр гүйцэтгэв.

Бүлэг А

**Хууль журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл
арга хэмжээ төлөвлөж батлуулсан байна.**

А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт салбарын болон орон нутгийн бодлогот нийцэж байна.

А.1.1 Эрх шилжүүлсэн ТАХ нь орон нутагт хэрэгжих бодлогын баримт бичигтэй нийцэж байна.

А.1.1.1 МУ-ын 2018 оны Төсвийн тухай хуулийн дагуу салбар сайдын багцаас тус аймагт 23.4 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр эрх шилжүүлэн, 4.6 тэр бум төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгохоор шийдвэрлэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч	ТАХ тоо	Төсөвт Өртөг	Санхүүжих дүн
БСШУСС	8	5030.6	1635.0
БХБС	5	11500.1	900.0
ЭМС	2	3665.4	991.0
ХНХС	1	3200.0	1000.0
ЗГХЭГ	1	35.0	35.0
ХХААХҮС	1	15.3	15.3
Дүн	18	23446.4	4576.3

А.1.1.2 Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байв.

А.1.2 Орон нутагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг төсөл нь экспертизээр батлагдаагүй ажлыг төлөвлөсөн байна.

А.1.2.1 Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалын 3.1-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төслийг хуулийн хугацаанд төлөвлөн 2017 оны 1/1480 тоот албан бичиг, нэмэлт хөрөнгө оруулалтын жагсаалтыг 1/1840 тоот албан бичгээр Сангийн яам болон холбогдох ТЕЗ-д хүргүүлэн ажилласан байна.

А.1.2.2 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа зураг төслийг экспертизээр батлуулсан байх журмыг¹ баримтлаагүй, хянагдсан зураг төсөлгүй ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

¹ Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан журмын 3.1-д Төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална: 3.2-д Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-д заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар нь инженерийн шугам сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник эдийн засгийн үндэслэл, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна.

А.2 Хууль журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

А.2.1 Орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нэр, хэрэгжүүлэх арга хэлбэр тодорхойгүй батлагдсан байна.

А.2.1.1 Төсвийн тухай хуулиар батлагдсан ТАХ-ний нэр, хүчин чадал, төсөвт өртгийг өөрчлөх саналыг явуулснаас ХАА-г зохион байгуулахад хугацаа алдсан байна. Тухайлбал:

Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар. Иххэт сум /XII.2.13/ Анх тус сумын 15 байрны дээврийг 1.6 тэр бум төгрөгөөр засварлахаар Төсвийн тухай хуульд тусгасан. Аймгийн Засаг даргын 2018 оны 1/1568 тоот албан бичгээр ТАХ-ний нэрийг “Иххэт сумын Нийтийн эзэмшлийн байруудын дээвэр гадна фасад дулаалга, зоорийн болон гадна инженерийн шугам сүлжээний засвар” гэж залруулах хүсэлтийг БХБС-д хүргүүлсэн. Тендерт зарцуулсан хугацаа /I.II.III багц/ 50-220 хоног.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн барилга. Сайншанд сум /X.2.1.1/: ХХҮЕГ-ын ТЭЗ-ийн төсөвт шинээр барихаар тусгасан боловч 2017 онд баригдсан барилгыг худалдан авахаар зохион байгуулсан байна. 2019 оны Төсвийн тухай хуульд ТАХ-г худалдан авахаар өөрчлөн тусгагдсан.

Цэцэрлэгийн барилга, 150 ор. Сайншанд сум /XIII.1.1.179/: ТАХ-г шинээр барихаар төсвийн тухай хуульд тусгасан. Аймгийн Засаг даргын 2018 оны 1/1626 тоот албан бичгээр батлагдсан 1.6 тэр бум төгрөгөөр 2 суманд цэцэрлэгийн барилга худалдан авах саналыг БСШУСС-дад хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй. ТАХ-ний хүчин чадал, тоо хэмжээ, байршилд өөрчлөлт оруулан, 2017 онд хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж эхэлсэн барилгыг худалдан авахаар зохион байгуулсан байна. 2019 оны Төсвийн тухай хуульд ТАХ-г худалдан авахаар тусгагдсан.

Сургуулийн барилга, 320 суудал /Сайншанд/: /XIII.1.1.79/ Жагсаалтад төсөвт өртөг нь 2.1 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төсөвт өртөг хүрэлцэхгүйгээс ХАА зохион байгуулахад хугацаа алдсан. БХТ төсөвт өртгийг 2.7 тэрбум төгрөгөөр баталгаажуулан, 2018 оны 6-р сарын 19-ний өдрийн 666/2018 тоот магадлалын дүгнэлт гарсан. Тендерт зарцуулсан хугацаа 186 хоног.

А.2.2. Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн ихэнх төсөл, арга хэмжээний зураг төсвийг жагсаалт батлагдсаны дараа боловсруулж, баталгаажуулсан байна.

А.2.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зураг төсөл нь батлагдаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4², Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3³ дэх заалтуудыг зөрчиж байна.

А.2.2.2 Мөн орон нутагт эрх шилжүүлсэн ТАХ-ний зураг төсвийг Төсвийн тухай хууль батлагдсаны дараа боловсруулж, баталгаажуулсан нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалт, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам”-ын 3.2 дах заалтыг зөрчиж байна. Тухайлбал:

Сургуулийн барилга, 320 суудал Сайншанд XIII.1.1.79: Барилгын хөгжлийн төв 2018 оны 6-р сарын 19-ний өдөр зураг төсвийг хянаж баталгаажуулж, 666/2018 тоот дүгнэлт гаргасан.

Сургуулийн дотуур байрны засвар Айраг XIII.4.1.16: Зураг төсөл боловсруулах ЗТГ-24/2018 тоот гэрээг 2018 оны 5-р сарын 1-нд байгуулсан.

² Төсвийн тухай хуулийн 29.4-д Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

³ Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-д Барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх;

Соёлын төвийн барилгын их засвар Алтанширээ XIII.2.2.7: Зураг төсөл боловсруулах ЗТГ-25/2018 тоот гэрээг 2018 оны 5-р сарын 1-нд байгуулсан.

Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар Иххэт сум XII.2.13 Багц1: Зураг төсөл боловсруулах ЗТГ-19/2018 тоот гэрээг 2018 оны 4-р сарын 3-нд байгуулсан.

Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, соёлын төвийн барилга Замын-Үүд XII.1.19: Зураг төсөл боловсруулах 04/2018 тоот гэрээг 2018 оны 05-р сарын 22-нд байгуулсан, БХТ 2018 оны 11-р сарын 19-нд хянаж баталгаажуулж 577/2018 тоот дүгнэлт гаргасан.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн засвар Сайншанд XVIII.2.1.2.9: Зураг төсөл боловсруулах ЗТГ-35/2018 тоот гэрээг 2018 оны 8-р сарын 03-нд байгуулсан.

Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар Иххэт сум XII.2.13 Багц3: Зураг төсөл боловсруулах ЗТГ-21/2018 тоот гэрээг 2018 оны 5-р сарын 15-нд байгуулсан. Магадлал хийлгэж дүгнэлт гаргуулаагүй.

A.2.3. Барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хуулийн дагуу гаргуулсан байна.

A.2.3.1 Захиалагч орон нутагт эрх шилжүүлэн шинээр хэрэгжүүлэх 5 барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг холбогдох хуулийн⁴ дагуу авч, барилгын ажлын талбайд тавигдах шаардлагыг⁵ хангасан байна.

A.2.4. Зураг төсөвт орсон өөрчлөлтийг магадлал хийлгэж, баталгаажуулсан байна.

A.2.4.1 Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан ТАХ-нд хуулийн⁶ дагуу магадлал хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.

A.2.4.2 МУ-ын 2018 оны Төсвийн тухай хуулийн XII.1.16-д тусгагдсан “Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, соёлын төвийн барилга Замын-Үүд сум” төсөл арга хэмжээний хүрээнд урьд нь баригдаж дуусаагүй орхигдсон барилгын үлдэгдэл санхүүжилт болох 3084.9 сая төгрөгт багтаан шинээр соёл, спортын барилга барих эрхийг орон нутагт шилжүүлсэн. Энэ ажлын зураг төсвийн магадлалын дүгнэлт нь /577/2018 тоот/ 2018 оны 11-р сарын 19-нд буюу барилгын ажил дуусаж байхад гарсан байна.

A.2.4.3 Барилгын тухай хуулийн 40.1.17-д “барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Соёлын төвийн барилгын их засвар Алтанширээ XIII.2.2.7: Барилгын засварын ажлын явцад дээвэр солихоор шийдвэрлэсэн боловч гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулаагүй,

⁴ Барилгын тухай хуулийн 37.1.3-д Захиалагч барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх;

⁵ Барилгын тухай хуулийн 16.1-д Захиалагч, гүйцэтгэгч барилга байгууламжийг барихаар олгогдсон газрын хил хязгаар, хэмжээг дур мэдэн өөрчлөхийг хориглоно. Газрын тухай хуулийн 31.4-д Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.

⁶ Барилгын тухай хуулийн 25.2.5-д энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөвт магадлал хийнэ гэж заасан. 25.5-д Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ.

- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн засвар Сайншанд XVIII.2.1.2.9: Зураг төсөл боловсруулах ЗТГ-35/2018 тоот гэрээг байгуулсан боловч зураг хийгээгүй.

А.2.5 Их засварын ажлыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн төлөвлөөгүй байна.

А.2.5.1 Салбар сайдын багцаас тус аймагт нийт 2.0 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 их засварын ажил, тоног төхөөрөмж нийлүүлэх 3 ажлын эрх шилжүүлэн 2018 онд 866.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн байна.

А.2.5.2 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 3.4-т “Төсвийн хөрөнгөөр хийх засварын ажлыг төлөвлөхдөө тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалыг үндэслэнэ” гэж заасан байтал эрх шилжүүлэн хэрэгжүүлэх их засварын 5 төсөл арга хэмжээ мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт, төсөвгүй байна.Үүнд:

- Айраг сумын сургуулийн дотуур байрны засвар
- Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар
- Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын гадна дулаан, цэвэр усны магистрал шугам, зоорийн хонгилын шугам, сүлжээний засвар шинэчлэлт
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн засвар
- ХХААГ-ын дээврийн засвар

А.2.5.3 Их засварын хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхдөө мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэх шаардлагатай байна.

А.2.5.4 МУ-ын 2018 оны Төсвийн тухай хуулийн ЗГХЭГ-ын даргын төсвийн багцаас “Сумдын ЗДТГ-ын автомашин” төсөл арга хэмжээний хүрээнд Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ-т автомашин худалдан авах эрхийг орон нутагт шилжүүлсэн. Зарим албан тушаалтны хариуцлагагүй байдлаас шалтгаалж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ тухайн суманд хэрэгжээгүй байна.

А.2.6 МУ-ын 2018 оны Төсвийн тухай хуулийн дагуу салбар сайдын багцаас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээнүүд нь хөрөнгө оруулалтын шинж чанарыг агуулсан байна.

Бүлэг Б

ХАА-г журмын дагуу зохион байгуулаагүйгээс хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр нөлөө хангалтгүй байна.

Б.1. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Б.1.1. Орон нутагт хэрэгжүүлэх эрхийг боломжтой хугацаанд шилжүүлсэн боловч тендерийн урилгыг хугацаа алдаж нийтэд мэдээлсэн байна.

Б.1.1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт ХАА зохион байгуулах эрхийг 2018 оны I, II улиралд шилжүүлсэн боловч орон нутагт хугацаа алдан III, IV улиралд тендер зарлаж байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

ТЕЗ-ийн нэр	ТАХ-ний тоо	Эрх шилжүүлсэн				Тендерийн урилга нийтэлсэн			
		Улирал				улирал			
		I	II	III	IV	I	II	III	IV
БСШУСС	8	3	4	-	1	1	2	3	-
БХБС	5	3	2	-	-	1	2	-	-
ЭМС	2	1	1	-	-	-	1	-	-
ХНХС	1	1	-	-	-	-	-	-	1
ЗГХЭГ	1	-	1	-	-	-	-	1	-
ХХААХҮС	1	-	1	-	-	-	1	-	-
Дүн	18	8	9	-	1	2	6	4	1

Б.1.1.2 БСШУСС-аас Сургуулийн барилга 320 суудал Сайншанд /ХИИ.1.1.79/ орон нутагт хэрэгжүүлэх эрхийг 2018 оны 1 сард шилжүүлсэн байхад 8-р сард, Цэцэрлэгийн барилга 150 ор Сайншанд /ХИИ.1.1.179/ 1 сард шилжүүлсэн байхад 9 сард, НХХС-аас Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн барилга Сайншанд /Х.2.1.1/ 2 сард шилжүүлсэн байхад 10 сард, ЗГХЭГ-аас Улаанбадрах сумын ЗДТГ-т автомашин нийлүүлэх /V.3.1/ эрхийг 4 сард шилжүүлсэн байтал 7 сард тендерийн урилга нийтэлсэн байна.

Б.1.2. Үнэлгээний хороог хуулийн дагуу байгуулсан байна.

Б.1.2.1 Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамжаар тухай бүр томилон ажиллуулсан байна. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор хуульд⁸ заасан шаардлага хангасан, худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн төлөөлөгч, албан тушаалтнуудыг оролцуулсан байна.

Б.1.2.2 Иххэт сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо тендерт оролцогчдын ирүүлсэн төсвийг хянаж,

⁷46.1.8-д барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх

⁸ ТБОНӨХБАҮХАТХуулийн 47.4-д Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

төсвийн нэмэгдэл зардлыг буруу тооцоолсон зөрчлийг илрүүлсэн боловч үнэлгээний дүгнэлт гаргахдаа зөрчлийн дүнг хасаж тооцоогүй байна. Цаашид тендерт оролцогчдоос ирүүлсэн төсвийг журмын дагуу үнэлэн, хянасан дүнг захиалагчид хүргүүлэх нь зүйтэй.

Б.1.3. Зарим тендерийн баримт бичгийг журмын дагуу боловсруулаагүй байна.

Б.1.3.1 Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолтыг тусгах учиртай.

Б.1.3.2 БХБС-ын 2018 оны 115 тоот тушаалаар Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, соёлын төвийн барилга /Замын-Үүд/ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад, аймгийн Засаг даргын 2018 оны 5/506 тоот захирамжаар Замын-Үүд сумын Засаг даргад эрхийг шилжүүлжээ.

Б.1.3.3 Замын-Үүд сумын Засаг даргын 2018 оны А/208 тоот захирамжаар томилогдсон Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэж боловсруулаагүй байна. Тухайлбал:

- Тендерийн баримт бичигт тендерт оролцогчид өгөх зааварчилгаа,
- тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт,
- тендер шалгаруулалтад ашиглах жишиг маягт бөглөх санамж,
- гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл,
- гэрээ байгуулах гэрээний маягт зэргийг тусгаж өгөөгүй байна.

Б.1.3.5 Техникийн тодорхойлолтод захиалагч өөрийн хэрэгцээ, шаардлагыг томъёолж өгөх ба тендерүүд түүнийг хангасан байх ёстой. Захиалагч хэрэгцээ шаардлагаа үндэслэл муутай, оновчтой бус тодорхойлсон, тендерт оролцогчид өгөх мэдээлэл тодорхойгүй байгаа нь сонгон шалгаруулалтын явцад өрсөлдөөнийг хязгаарлах, тодорхой бэлтгэн нийлүүлэгчид давуу тал олгох байдал ажиглагдаж байна.

Б.1.4. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Б.1.4.1 Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь аймгийн Засаг даргаар, Замын-Үүд сумын ЗАА нь сумын Засаг даргаар 2018 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг батлуулан ТБОНӨХБАҮХАТухай хуульд заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтад тендерийн урилгыг байршуулж нийтэлсэн байна.

Б.1.4.2 Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны 50 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын, 14.3 хувийг харьцуулалтын, 35.7 хувийг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан байна.

Б.1.4.3 Тендер нээх үед хуульд⁹ заасан мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэх байтал зарим тендерийн нээлт дээр өөр үйл ажиллагаа явуулан, шийдвэр гаргасан байна.

Б.1.4.4 ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 29.3-д «Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл энэ хуулийн 20.7.2-т заасан нөхцөл үүссэн бол түүнд олгосон гэрээ байгуулах эрхийг захиалагч хүчингүй болгож, удаах “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд ийм оролцогч байхгүй бол 30.4-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана, 30.1.3-д шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн тохиолдолд бүх тендерээс татгалзана гэж заасан. Гэтэл оролцогчдоос гомдол гарахад бусад оролцогчийн өрсөлдөх боломжийг хязгаарлан бүх тендерээс татгалзан, дахин зарлан хугацаа алдсан байна.

Б.1.4.5 Тендерийн үнэлгээг зохих журмын дагуу хийгээгүйгээс ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 55.1-д заасны дагуу 2 тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд дараах гомдол гарсан байна.

- Сургуулийн барилга, 320 суудал /Сайншанд/: Төсөвт өртөг 2.1 тэрбум төгрөгөөр батлагдсан байтал үнэлгээний хороо 2.7 тэрбум төгрөгийн төсөвтэй тендерийг шалгаруулан, гэрээ байгуулах эрхийг олгосон.
- Нэгдсэн эмнэлгийн дээврийн засвар /Сайншанд/: Тендерийн бичиг баримтад заасан шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан.

Б.1.4.6 Үнэлгээний хороо ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 28.3-д “Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна” гэсэн заалтыг мөрдөөгүй байна. Зарим тендерийг үнэлэхдээ оролцогчийн ирүүлсэн төсвийн тооцооллыг хянаагүй зөвхөн санхүүгийн болон техникийн чадавх үнэлэн шалгаруулалтыг зохион байгуулсан байна. Тухайлбал:

- Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын дээврийн засвар, гадна фасад /Иххэт/ багц2
- Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, соёлын төвийн барилга /Замын-Үүд/
- Соёлын төвийн барилгын их засвар /Алтанширээ сум/

Б.1.4.7 Захиалагч тендер амжилтгүй болж шууд гэрээ байгуулах аргыг сонгохдоо хуульд¹⁰ заасан шаардлага, чадавх, техникийн тодорхойлолт бусад нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг үнэлдэггүй байна.

Б.1.5. Худалдан авах ажиллагааны тайланг журмын дагуу боловсруулж, хугацаанд нь тайлагнасан байна.

⁹ ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 26.3-д Тендер нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, тендерийг хувилбарт саналтайгаар ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хувилбарт саналын үнэ, мөн тендерт тусгасан үнийн хөнгөлөлт, тендерийн баталгаа ирүүлсэн эсэх, оролцогч өөрийн тендерийг өөрчилсөн, эсхүл татгалзсан тухай мэдээллийг захиалагч зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. 26.4.Энэ хуулийн 26.2-т заасан этгээд, захиалагч байгууллагын төлөөлөгч энэ зүйлийн 26.3-т заасан тэмдэглэлд гарын үсэг зурна. 26.5.Энэ хуулийн 26.3-т заасан тэмдэглэлийг сонирхсон этгээдэд танилцуулна. 26.6.Тендер нээх үед энэ хуулийн 26.3-26.5-д зааснаас бусад үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахыг хориглоно.

¹⁰ ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 34.2-д Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

Б.1.5.1 ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу худалдан авах ажиллагаа явуулсан тухай тайлан бичиж, тендер шалгаруулалтын хавтас хэрэг үүсгэн, баримтын бүрдлийг ханган ажилласан байна.

Б.1.5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдаж, орон нутагт эрх шилжин хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг Сангийн сайдын 2016 оны 415 тушаалын журмын 6-р хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, тухайн төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна.

Б.2. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу гүйцэтгэх үүргээ бүрэн биелүүлэхгүй байна.

Б.2.1 Хөрөнгө оруулалтыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу гүйцэтгээгүй байхад комисс хүлээн авсан байна.

Б.2.1.1 Барилга байгууламж ашиглалт оруулах комисс ЗГ-ын 2017 оны 69 тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.1¹¹, 4.4¹², 4.7¹³ заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Б.2.1.2 Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг техникийн тодорхойлолт, зураг төсөл, төсвийн дагуу хийж гүйцэтгээгүй, ажил дуусаагүй байхад комиссын актаар хүлээн авсан байна. Тухайлбал:

- *Замын-Үүд сумын Соёл, спортын барилгын ажлыг* 3084.1 сая төгрөгөөр Гантулга трейд ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч зураг төсөл, техникийн тодорхойлолтод тусгагдсан агаар халаагч бш, гадна инженерийн байгууламжийн ажлыг гүйцэтгээгүй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эх үүсвэр нь батлагдсан байтал гүйцэтгээгүй зарим ажлыг сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийхээр шийдвэрлэсэн байна. Зам талбайн ажлыг Гантулга трейд ХХК, гадна цэвэр, дулаан, ус хангамжийн ажлыг Чандмань Бадрал ХХК, гадна цахилгааны шугамын ажлыг Уртын уул ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн нийт 161.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
- Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар Иххэт сум багц1: Засварын ажлыг БЭМЭС ХХК гүйцэтгэсэн бөгөөд зарим байрны дээвэрт хар цаас хийхээр ажлын тоо хэмжээнд тусгагдсан байтал уур ус тусгаарлах полимер буюу ногоон өнгийн шилэн даавуу материалаар сольж хийсэн.
- *Алтанширээ сумын Соёлын төвийн барилгын их засварын ажлыг* 137.6 сая төгрөгөөр Тольт дэнлүү ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээнд тусгагдсан зарим ажлыг гүйцэтгээгүй байна. Ханыг хөвөн обойгоор өнгөлөх 108.9м², ложны нүүрний хэсгийг эсгий хавтангаар өнгөлөх 12.5м² ажил хийгдээгүй, 3D хавтангаар ложны тааз, багана бүрэх 22.9м² ажлын материалыг сольж өнгөт хавтангаар хийсэн, бүжгийн заланд гипсэн

¹¹ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.1-д Барилга байгууламж ашиглалтад оруулах комисс (цаашид “комисс” гэх) дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

¹² ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.4-д Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын гишүүд хариуцсан асуудал тус бүрээр санал гаргана. Комиссын нийт гишүүдийн саналыг үндэслэн комиссын дүгнэлтийг гаргах бөгөөд уг дүгнэлтийг комиссын нийт гишүүд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

¹³ ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.7-д Комиссын гишүүд үүрэг, даалгавар бүрээр гүйцэтгэсэн ажлын биелэлтэд урьдчилан үнэлэлт, дүгнэлт өгсөн байх бөгөөд комиссын хуралдаанаар үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн хэлэлцэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

хавтангаар уналттай тааз хийх 105.4м² ажлыг дутуу гүйцэтгэн уналттай тааз хийгээгүй, гипсэн хавтангаар бүрж, хүрээ наасан байна.

- *Иххэт сумын Цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг 70.0 сая төгрөгөөр Чандмань Илч ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Техникийн тодорхойлолтод тусгагдсан халаах хэрэгсэл угсраагүйгээс хүчин чадал нь хүрэлцэхгүй, холбох хэрэгсэл чанаргүй, холболтын ажлыг хангалтгүй хийснээс ус байнга алдаж труба хоолой, халаах хэрэгсэл нь зэвэрч муудсан.*

Б.2.1.3 Зарим гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг гэрээний дагуу чанартай гүйцэтгээгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал:

- *Нийтийн эзэмшлийн орон сууцны байрнуудын дээврийн засварын Иххэт сум багц3:* Зарим байруудын зоорийн хонгилд угсарсан дулааны шугамаас ус гоожсон, дулаалга унасан, бохирын шугам солигдоогүй, труба хагарч ус гоожсон.
- *Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар Иххэт сум багц1:* Зарим байрны орцны сольсон хаалганы материал хангалтгүйгээс гагнаасаараа салсан, төмөр нь урагдаж унасан.
- *Цэцэрлэгийн барилгын их засварын ажил Иххэт сум:* Халаах хэрэгслийн холбох хэрэгсэл чанаргүй, холболтын ажлыг хангалтгүй хийснээс ус байнга алдаж труба хоолой, халаах хэрэгсэл нь зэвэрч муудсан.

Б.2.1.4 Хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу бүрэн гүйцэтгэсэн эсэхийг хянаж, хүлээн авах шаардлагатай байна.

Б.2.2 Гүйцэтгэгч барилгын ажлын явцад захиалагч, зохиогчийн шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Б.2.2.1 Барилга байгууламж ашиглалтад оруулах комисс нь журамд¹⁴ заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй байна. Комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцэн тэмдэглэл үйлдээгүйгээс дутуу орхигдсон ажлыг хэрхэн гүйцээх нь тодорхойгүй байна. Тухайлбал:

- Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, соёлын төвийн барилга /Замын-Үүд/: Авто зогсоол гэрэлтүүлэг, агаарын хөшиг бш суурилуулах, ариун цэврийн өрөөний хаалт хийх, газардуулгын хэмжилт хийх зэрэг ажлууд хийгдээгүй орхигдсон
- Цэцэрлэгийн барилгын их засвар Иххэт. Комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг үнэлээгүй.

Б.2.2.2 Барилгын ажлын ихэнх гүйцэтгэгч хуульд¹⁵ заасны дагуу барилгын ажлын ил, далд ажлын актыг тухай бүр баталгаажуулан, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

¹⁴ ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.4-д Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын гишүүд хариуцсан асуудал тус бүрээр санал гаргана. 4.7-д Комиссын гишүүд үүрэг, даалгавар бүрээр гүйцэтгэсэн ажлын биелэлтэд урьдчилан үнэлэлт, дүгнэлт өгсөн байх бөгөөд комиссын хуралдаанаар үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн хэлэлцэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана: ЗГ-ын 2018 оны 317 тушаалаар батлагдсан дүрэм.

¹⁵ Барилгын тухай хуулийн 40.1.2-д барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

Б.2.2.3 Гүйцэтгэгч барилгын тухай хуулийн 40.1.20-д “гарал үүсэл, тохирлын гэрчилгээтэй барилгын материал хэрэглэх” гэсэн заалтыг мөрдөж ажиллахгүй байна. Барилгын ажилд ашигласан ихэнх материалын гарал үүслийн гэрчилгээ байхгүй, импортоор ирсэн материалын гарал үүслийн гэрчилгээ тодорхойгүй, орчуулга хийгдээгүй байна.

Б.1.4.7. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэгч, ажил эхлэх дуусах хугацааны болон хуульд¹⁶ заасан бусад мэдээллийг багтаасан самбарыг ажил үйлчилгээний баталгаат хугацаанд байршуулаагүй байна.

Б.2.3 Гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан нь нотлогдохгүй байна.

Б.2.3.1 Салбар сайдын багцаас тус аймагт 23.4 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл арга хэмжээ хэрэгжүүлж, 4.6 тэр бум төгрөгийн санхүүжилтийг 2018 онд олгохоор шийдвэрлэснээс 16 ТАХ хэрэгжүүлж 4.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Б.2.3.2 **50 ортой төрөх эмнэлгийн барилга Сайншанд. XVIII.1.6** 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1-р хавсралтаар батлагдсан “Төрөх эмнэлэг 50 ор Сайншанд” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах /гэрээ байгуулах, цуцлах/ эрхийг эрүүл мэндийн Сайдын багцаас аймгийн Засаг даргад шилжүүлсэн. ОНӨГ-аас 2017 онд ХАА зохион байгуулж, Төрөх эмнэлгийн барилгын дуусгалтын ажлыг 1.7 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Баярс констракшн ХХК-тай гэрээ байгуулжээ. Эмнэлгийн барилгын дуусгалтын ажлын явцад 2.3-р давхрыг ашиглах боломжгүй дүгнэлт гарснаар эмнэлгийн барилгаас 1 давхар, зоорийн хэсгийг дуусгахаар болсон.

Б.2.3.3 Гүйцэтгэгч эмнэлгийн барилгын дуусгалтын ажлаас зоорь, 1 давхрын ханын өрөг, шал, заслын болон бусад нэмэлт ажлуудыг гүйцэтгэсэн бөгөөд 2018 онд хувийн хөрөнгөөр шинээр эмнэлгийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.

Б.2.3.4 Баярс констракшн ХХК-ийн Барилга угсралт, засварын ажлын гүйцэтгэлийг 2017 онд ЭМЯ, 2018 онд аймгийн ГХБХБГ хянан баталгаажуулан 2017 онд 850.0 сая төгрөг, 2018 онд 790.0 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас олгожээ. Нийт гаргасан гүйцэтгэл, олгосон 1640.0 сая төгрөгийн санхүүжилтээс **50 ортой, төрөх эмнэлгийн барилгын** дуусгалтын ажилд хэдийг зарцуулсан нь тодорхойгүй, дуусгалтын ажлын бодит гүйцэтгэл байхгүй байна.

Б.2.3.5 Гүйцэтгэгчээс дуусгалтын ажлын гүйцэтгэлийг гаргуулж, хянан баталгаажуулах тухай албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлэв.

Б.2.3.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн барилга /Дорноговь, Сайншанд сум/ Х.2.1.1: Барилга нийлүүлэхээр шалгарсан Гантулга трейд ХХК-тай 2.9 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгож, Худалдан авах УТ-НТШ-06/2018 тоот гэрээг байгуулсан байна.

¹⁶ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 46.1.9-д Захиалагч гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах.

Б.2.3.6 Нийлүүлэгдсэн дээрх барилгыг “Дорноговь Их Хөгжил сан” ТББ-ын хөрөнгийн эх үүсвэрээр барихаар 2017 онд Гантулга трейд ХХК-тай 3.2 тэрбум төгрөгийн 17/01 тоот гэрээ байгуулж, комиссын 2017 оны КД-54/2017 тоот дүгнэлтээр ашиглалтад оруулсан байна.

Б.2.3.7 Сургуулийн дотуур байрны засвар Айраг: Гүйцэтгэгч засварын ажлын явцад барилгын гэрэлтүүлгийг ашиглах боломжгүй болгосон, аяга таваг угаах дамжлага бүхий тосгуурын бохирын шугам, газардуулгыг салгасан. Ашиглах боломжгүй болгосон хөрөнгийг магадалшгүй ажлын зардалд хянан 1.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Б.3. Захиалагчийн тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Б.3.1 Захиалагчийн хяналтыг журмын дагуу томилж хэрэгжүүлээгүйгээс хууль журмын дагуу хийгдэх улсын хяналт орхигдсон байна.

Б.3.1.1 ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 46.1.6-д заасны дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавихаар аймгийн ЗДТГазар ГХБХБГ-аар, Замын-Үүд сумын ЗААлба барилгын улсын байцаагчаар захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулжээ. Захиалагч Засгийн газрын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.8-д¹⁷ заасны дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг томилоогүй байна.

Б.3.1.2 Аймгийн ЗДТГ нь улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжүүлэн хэрэгжсэн 10 ТАХ-ний захиалагчийн хяналтыг ГХБХБГ-аар хэрэгжүүлж, захиалагчийн техник хяналтын зардлын 70 хувь буюу 23.2 сая төгрөгийг гэрээний дагуу олгосон байна.

Б.3.1.3 ГХБХБГ барилгын ажлын явцад хяналт шалгалт хийж, ил далд ажлын акт болон гүйцэтгэлийг баталгаажуулах, барилга, засвар шинэчлэлийн ажлыг норм дүрэм технологийн дагуу гүйцэтгүүлэх талаар заавар зөвлөмж өгч, талбайн журналд тэмдэглэгээ хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах зэргээр захиалагчийн хяналтыг төсөл арга хэмжээ тус бүрт хэрэгжүүлж ирсэн байна.

Б.3.1.4 Засгийн газрын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1.3-д “Орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн хэрэгжүүлнэ” гэж заасан байтал Замын-Үүд сумын ЗАА нь эрх шилжүүлэн хэрэгжсэн 1 ТАХ-ний захиалагчийн техникийн хяналтыг сумын барилгын улсын байцаагчаар хийлгэхээр гэрээ байгуулж, 2019 оны 3 сард 13.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Б.3.1.5 Улсын байцаагч нь тодорхой салбарт дагаж мөрдөхөөр тогтоосон журмын биелэлтэд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд шаардлага тавьж, биелэлтийг хангуулан ажиллах байтал барилгын ажлын үе шатанд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

¹⁷ Засгийн газрын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.8-д Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна.

Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль¹⁸, Барилгын тухай хуулийн 47 дэх заалтыг зөрчиж байгаа бөгөөд илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгуулах, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг тогтоох байцаагчийн улсын хяналт¹⁹ орхигдоход хүргэж байна.

Б.3.1.6 Хууль тогтоомж зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.3.2 Зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

Б.3.2.1 ЗГХЭГ-аас Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ-т автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг орон нутагт шилжүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иххэт сумын Засаг дарга санхүүжилтийн эх үүсвэр нь батлагдаагүй, худалдан авах эрх олгогдоогүй байхад 2018 оны 4 сард автомашин дур мэдэн авч, байгууллагын хөрөнгийн дансанд 31.5 сая төгрөгөөр тусган ашиглаж байна.

Б.3.2.2 Тус суманд худалдан авсан автомашины төлбөрийг барагдуулахаар 2018 оны 6-р сард Улаанбадрах сумын ЗДТГ-т автомашин нийлүүлэх ХАА зохион байгуулж, хөрөнгө хүлээлцсэн баримтад гарын үсэг хуурамчаар үйлдэн 35.0 сая төгрөгийн санхүүжилтийг нийлүүлэгчид олгосон байна.

Б.3.2.3 Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.4-д “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”. 41.2.6-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Б.3.2.4 ЗГХЭГ-ын даргын тушаалын дагуу Улаанбадрах сумын ЗДТГ-т автомашиныг шилжүүлэх, НББ-д залруулга хийх албан шаардлага бичихээр шийдвэрлэв.

Б.3.3 Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргаж, эрх шилжүүлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Б.3.3.1 Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланг Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасан маягтуудын дагуу нэгтгэж хугацаанд нь эрх шилжүүлсэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна. Тухайлбал:

¹⁸ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д Мэргэжлийн хяналтын улсын байцаагч дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.9.1-д хууль тогтоомжоор болон түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас удирдлагын тодорхой салбарт нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон тусгай журмын биелэлтэд хяналт тавих; 10.9.8-д хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

¹⁹ Барилгын тухай хуулийн 4.1.19-д “барилга байгууламжийн техникийн улсын хяналт” гэж барилгын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг тогтоохоор хяналт хэрэгжүүлэх эрх бүхий хуулийн этгээдээс хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ;

- ХАА-ний жилийн эцсийн тайланг 2019 оны аймгийн Засаг даргын 2019 оны 1-р сарын 11-ны өдрийн 1/56 тоот албан бичгээр
- ХАА-ны хагас жилийн тайланг 2018 оны 6-р сарын 11-ний өдрийн 01/1132 тоот албан бичгээр тус тус хугацаанд хүргүүлсэн байна.

Б.3.4 Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

Б.3.4.1 Захиалагч гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн гүйцэтгэгчид хариуцлага тооцон ажиллаагүй байна.Тухайлбал:

- *Цэцэрлэгийн барилгын их засвар Иххэт:* Улсын комиссын 2018 оны БЗ-14/2018 тоот дүгнэлтээр хүлээн авсан. Халаах хэрэгслийн хүчин чадал хүрэлцэхгүйгээс анги танхим хүйтэн, гомдол их гарсан, холбох хэрэгслээс ус байнга алдаж турба хоолой, халаах хэрэгсэл нь зэвэрч муудсан.

Б.3.4.2 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн засвар Сайншанд XVIII.2.1.2.9: Барилгын дээврийн засварын ажлын зураг төсөл боловсруулах 450.0 мянган төгрөгийн ЗТГ-35/2018 тоот гэрээг Сант Номун ХХК-тай байгуулжээ. Аудитын явцад дээврийн засварын ажлын зураг ирүүлээгүй болно.

Б.4.Хөрөнгө оруулалтын үйл явцад журмын дагуу хяналт тавьж үнэлсэн байна.

Б.4.1 Санхүү төрийн сангийн хэлтэс хөрөнгө оруулалтын санхүүжилтийг журмын дагуу хянан олгосон байна.

Б.4.1.1 МУ-ын Сангийн сайдын 2019 оны 6-1/1469 тоот албан бичгээр Дорноговь аймгийн Худалдан авах ажиллагааны 2018 оны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн тухай мэдээллийг ирүүлсэн байна. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 90 оноо бүхий шалгуур үзүүлэлтээс 78 оноо авч, “сайн” гэж үнэлэгдсэн байна. Үнэлгээний явцад дараах зөрчил илрүүлсэн байна.

- Тендер шалгаруулалтын үр дүнг бүрэн мэдээлээгүй
- ХАА-нд гарсан гомдлын 50 хувь нь хуульд нийцээгүй шийдвэр гаргасан

ХАА-г зохион байгуулахдаа гаргасан зөрчлийг давтахгүй байх, ХАА-ны үйл явцыг тухай бүр цахимд оруулж илд тод байдлыг хангаж ажиллах талаар зөвлөмж ирүүлсэн байна.

Б.4.1.2 Аймгийн ЗДТГ-ын СТС-ийн хэлтэс улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар нийт 4.9 тэр бум төгрөгийн санхүүжилт авч, салбар сайдын багцаас санхүүжилт хүлээн авах төрийн сангийн тоот дансанд орлогын нийт 19, зарлагын 41 гүйлгээ хийсэн байна. Аймгийн Засаг даргын баталсан Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эрх нээх жагсаалт, ХАА-ны холбогдох баримт, хянан баталгаажсан ажлын гүйцэтгэл, хүлээн авсан комиссын акт зэрэг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын журмын 4.5-д заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгосон байна.

Б.4.2 Аймгийн ИТХ-аас хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

Б.4.2.1 Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 46 дугаар тогтоолоор Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2016-2018 онд хийгдсэн ажлуудын гүйцэтгэл, үр дүнд хөндлөнгийн хяналт шалгалтыг Сайншанд, Замын-Үүд сумдад зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, хяналт шалгалтын удирдамжийг баталсан байна. Шалгалтын дүнг хэлэлцэн 7 үүрэг чиглэлийг аймгийн Засаг даргад хүргүүлэн ажилласан байна.

Б.4.2.2 Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан. Дорноговь аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь улсын болон орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шалгалт үнэлэлт дүгнэлт гаргаагүй байна.

Бүлэг В

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцдоггүй байна.

В.1 Улсын төсвийн зарим хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтод түвшинг хангахгүй байна.

В.1.1 Эрх шилжүүлсэн зарим төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

В.1.1.1 Эрх шилжүүлсэн дараах ТАХ-ний ажлын тоо хэмжээ тодорхойгүй, санхүүжилт орон нутагт шилжиж ирээгүй, өмнөх гүйцэтгэгчийн хариуцлагагүй байдал зэргээс шалтгаалан хэрэгжүүлээгүй, тухайн жилд хүрэх зорилт хангагдаагүй байна.

- *Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эмнэлэг, 100 ор /Замын-Үүд/:* 2014 оноос хойш барилгын ажил зогссон. Барилгын ажлын явц 75 хувьтай. 2018 оны төсөвт тусгагдсан 633.0 сая төгрөгийн санхүүжилтийг БХБЯ олгосон,
- *Спорт цогцолборын барилгын дуусгал Хатанбулаг:* 2016 оноос хойш барилгын ажил зогссон, ажлын явц 70 орчим хувьтай. 2018 онд улсын төсөвт 110.0 сая төгрөг батлагдаж, ХАА зохион байгуулах эрх шилжиж ирсэн. Өмнөх гүйцэтгэгчийн гэрээг дүгнээгүй, ажлын тоо хэмжээ тодорхойгүй байна. Аймгийн Засаг даргын 2018 оны 1/1573 албан бичгээр гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, үлдэгдэл ажлыг магадлалын дүгнэлтээр баталгаажсан төсвийг ирүүлэх хүсэлтийг БСШУСС-д хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна.
- *50 ортой төрөх эмнэлгийн барилга Сайншанд:* 2011 онд баригдаж эхэлсэн төрөх барилгын 2,3-р давхрын бетон хийцүүд БНБД-ийн шаардлага хангахгүй байгаа нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр нотлогдож, албадан буулгах шийдвэрийг аймгийн Засаг даргын захирамжаар гаргасан боловч хэрэгжээгүй байна. Дуусгалтын ажил дуусаагүй байна.

В.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцоогүй байна.

В.2.1 Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, бодит үр нөлөөг тооцоогүй байна.

В.2.1.1 Хөрөнгө оруулалтын үр ашгийг төсөл арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, бодит үр нөлөөг тооцох эрх зүйн зохицуулалт байхгүйгээс тооцон ажилладаггүй байна.

В.2.2 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг батлагдсан төсөвт өртгийн дүнд багтаан гүйцэтгэсэн байна.

В.2.2.1 Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээнд 4.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 4.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна.

Салбар сайдын багцын хүрээнд олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулав.

ТЕЗ	ТАХ тоо	Төсөвт өртөг	Сая.төгрөгөөр	
			Санхүүжих дүн	Санхүүжилт олгосон
БСШУСС	8	5030.6	1635.0	1,514.4
БХБС	5	11500.1	900.0	885.0
ЭМС	2	3665.4	991.0	929.5
ХНХС	1	3200.0	1000.0	1,500.0
ЗГХЭГ	1	35.0	35.0	35.0
ХХААХҮС	1	15.3	15.3	-
Дүн	18	23446.4	4576.3	4,863.9

В.2.2.2 Эрх шилжүүлсэн зарим хөрөнгө оруулалтыг тухайн жилд санхүүжүүлэхээр батлагдсан дүнгээс илүү санхүүжилтийг олгосон байна. Тухайлбал:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн барилга Сайншанд сум Х.2.1.1/: Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар тухайн жилд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдан боловч салбар яамнаас 0.5 тэрбум төгрөгийг нэмж, нийт 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна.

В.2.3 Өмнөх аудитаар өгсөн зарим зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

В.2.3.1 Өмнөх аудитаар 2 албан шаардлага, 4 зөвлөмж өгөгдсөнөөс дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

- Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, хариуцлага тооцох
- Зураг төсөл зохиогчийн болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээг дүгнэх, хариуцлага тооцон ажиллах

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Улсын төсөвт хууль журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулаагүй байна.
- Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг жагсаалт батлагдсаны дараа боловсруулж, баталгаажуулсан байна.
- Их засварын ажлыг төлөвлөхдөө мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслээгүй байна.
- Орон нутагт хэрэгжүүлэх эрхийг боломжтой хугацаанд шилжүүлсэн боловч тендерийн урилгыг хугацаа алдаж нийтэд мэдээлсэн байна.
- Зарим тендерийн баримт бичгийг журмын дагуу боловсруулаагүй, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
- Худалдан авах ажиллагааны тайланг журмын дагуу боловсруулж, хугацаанд нь тайлагнасан байна.
- Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу гүйцэтгэх үүргээ бүрэн биелүүлэхгүй байхад комисс хүлээн авсан байна.
- Гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан нь нотлогдохгүй байна.
- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргаж, эрх шилжүүлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.
- Аймгийн ИТХ-аас хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавин ажилласан байна.
- Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, бодит үр нөлөөг тооцоогүй байна.

Аудитаар нийт 1162.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 838.4 сая төгрөгийн 3 албан шаардлага бичлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин танаа:

- Улсын төсөвт хууль журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулах

Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг танаа:

- Хөрөнгө оруулалтыг чанартай бүрэн гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авахад анхаарч ажиллах

ОНӨГ-ын дарга У.Баярбилэг, Замын-Үүд сумын ЗАА-ны дарга Ц.Саруулсайхан нар танаа:

- Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллах.

ГХБХБГ-ын дарга Ц.Оюунсайхан танаа:

- Хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу бүрэн гүйцэтгэсэн эсэхийг хянах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**ДОРНОГОВЬ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон,
Утас/факс: (705) 2-30-03
E-mail: dornogobi_mgl@yahoo.com

2019. 04. 09 № 3/631
танай 2019. 04. 08 -ны № 16/392 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагын 2019 оны 1-6/393 тоот албан бичгээр ирүүлсэн Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт:1.....хуудастай.

ДАРГА  Б. ГАНЗОРИГ

51. ххбвч
2019. 04. 10

44 8 10507

D:\2019\ZAH-TOOT

1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн засварын ажлын зураг төслийг Сант номун ХХК хийсэн бөгөөд зургийг хавсралтаар хүргүүлж байна.

2. Алтанширээ сумын Соёлын төвийн засварын ажлын төсөвт өртөгт дээвэр засварлах ажил огт тусгагдаагүй байсан бөгөөд засварын явцад дээврээс ус гоожсон тул дахин төсөв хийлгэж, зарим ажлыг хасч, дээврийг бүхэлд нь шинэчилсэн байна. Гэтэл аудитын тайлангийн Б.2.1.2-д хийгээгүй ажлуудыг дурьдаж, төсөвт тусгаагүй боловч хийгдсэн ажлыг бичээгүй байна.

3. Гүйцэтгэгч компани гэрээний эцсийн хугацаанд багтаж ажлаа дуусган, комисс ажиллуулах хүсэлт ирүүлсэн бол захиалагч байгууллага хугацаа хэтэрсэнд тооцох боломжгүй. Учир нь ажил хүлээн авах комиссын гишүүд бүрдэх гэж хугацаа алддаг, мөн нэг дор ойрхон сумдын ажлуудыг хамтатгаж явах ч үе байдаг. Гэтэл аудитын тайланд комисс ажилласан хугацаагаар тооцож, гэрээний хугацаа хэтэрсэн гэж үзэх нь буруу юм. Тухайлбал:

- Алтанширээ сумын Соёлын төвийн засварын ажлын гэрээний хугацаа 2018.10.10-ны өдөр дууссан. Гүйцэтгэгч компани комисс ажиллуулах хүсэлтээ 2018.10.09-ний өдөр өгсөн. 2018.10.15-ны өдөр комисс ажилласан байна. Гэтэл аудитаас 5 хоног хэтэрсэн гэж үзжээ.

- Айраг сумын Сургуулийн дотуур байрны засварын ажлын гэрээний хугацаа 2018.08.10-ны өдөр дууссан. Гүйцэтгэгч компани комисс ажиллуулах хүсэлтээ 2018.07.30-ны өдөр өгсөн. 2018.09.12-ны өдөр комисс ажилласан байна. Гэтэл аудитаас 19 хоног хэтэрсэн гэж үзжээ.

- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн засварын ажлын гэрээний хугацаа 2018.11.20-ны өдөр дууссан. Гүйцэтгэгч компани комисс ажиллуулах хүсэлтээ 2018.11.19-ний өдөр өгсөн. 2018.12.06-ны өдөр комисс ажилласан байна. Гэтэл аудитаас 15 хоног хэтэрсэн гэж үзжээ.

- Иххэт сумын нийтийн эзэмшлийн орон сууцны дээврийн засварын ажлын гэрээний хугацаа 2018.09.20-ны өдөр дууссан. Гүйцэтгэгч компани комисс ажиллуулах хүсэлтээ 2018.09.19-ны өдөр өгсөн. 2018.09.27-ны өдөр комисс ажилласан байна. Гэтэл аудитаас 7 хоног хэтэрсэн гэж үзжээ.

- Иххэт сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлын гэрээний хугацаа 2018.08.25-ны өдөр дууссан. Гүйцэтгэгч компани комисс ажиллуулах хүсэлтээ 2018.08.25-ны өдөр өгсөн. 2018.09.06-ны өдөр комисс ажилласан байна. Гэтэл аудитаас 10 хоног хэтэрсэн гэж үзжээ.

4. Аудитын тайлангийн В.2.3.1-д өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг /гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, хариуцлага тооцох/ хангалтгүй хэрэгжүүлсэн гэсэн хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Учир нь захиалагчийн зүгээс аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, гэрээний хугацаанд хяналт тавьж, хугацаандаа хийж амжаагүй ажлууд дээр гүйцэтгэгч байгууллагын хүсэлтийг харгалзан үзэж, гэрээг сунгаж ажилласан болно.

Тайлбар бичсэн: ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн



А.Амгаланзаяа

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР


Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн саналд:

1. Аудитын дүнгийн Б.3.4.2-т ирүүлсэн саналыг хүлээн авч “Аудитын явцад дээврийн засварын ажлын зураг ирүүлээгүй болно” гэж нэмж тусгав.
2. Аудитын дүнгийн Б.2.1.2-д ирүүлсэн санал нь нэмэлт тайлбар тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.
3. Аудитын дүнгийн Б.3.4.3-т ирүүлсэн саналыг хүлээн авч, дүнгийн хэсгээс хасч өөрчлөлт оруулав.
4. Аудитын дүнгийн В.2.3.1-т ирүүлсэн саналд: Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэсэн тайлан, нотлох баримт ирүүлээгүй тул дүнгийн хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.


ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Аудитор  П.Энхбаяр

ХЯНАСАН:

Аудитын багийн ахлах, менежерийн үүргийн
Түр орлон гүйцэтгэгч  Ц.Лүндэгмаа

4417144353
ЕНӨА0056 9025707
АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.

2019 он

Аудитын код: ГАГ-2019/01-ГА

27

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/сг

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 04 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.3, 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.2, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж үр дүнг 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ, Замын-Үүд сумын ЗАА-ны дарга нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Замын-Үүд сумын ЗАА, ОНӨГ, ГХБХБГ-ын дарга нарт хүргүүлсүгэй.
5. Акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгчид үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА